БАТЛАВ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ц.БАЗАРРАГЧАА

БАЯНТЭЭГ ТӨХК

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Тэсэлгээний ажил гүйцэтгэх ажлын даалгавар

Гүйцэтгэгч нь батлагдсан зураг төсөл, ажлын төлөвлөгөө, захиалагч талын чиглэл зааварчилгаа болон ХАБЭА, БО-ны стандарт, дүрэм журам, "Тэсрэх дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль дүрэм", Баянтээг Хувьцаат Компанийн дүрэм журам, холбогдох хууль тогтоомж, Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын 2-р багт байрлах "Баянтээг" чулуун нүүрсний ордын хөрсний чулуулагт стандартын шаардлагад нийцсэн чанартай бүтээгдэхүүн, дэвшилтэт технологиор тэсэлгээг мэргэжлийн өндөр түвшинд аюул осолгүй, бутлан сийрэгжүүлэх ажил хийж гүйцэтгэнэ.

Хийгдэх ажил

1. Гүйцэтгэгч нь тэсэлгээний ажлын жишиг төсөл, тухайлан тодорхой нөхцөлд

гүйцэтгэдэг тэсэлгээний ажлын зураг төсөл боловсруулж мөрдөж ажиллана.

Жишиг төслийг тухайн ашигт малтмалын ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл, туршилт болон үйлдвэрлэлийн тэсэлгээний ажлын үр дүн, шинжлэх ухаан техникийн судалгаа, ижил, төстэй нөхцөл дэх үйлдвэрлэлийн тэсэлгээний ажлын туршлага болон "Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллааганы нэгдсэн дүрэм"-ийн шаардлагад үндэслэн боловсруулна.

2. Гүйцэтгэгч нь тухайн төсөлд дараах шийдлүүдийг тусгасан байна.

2.1. Тэсэлгээний ажлын үндсэн хэмжээсүүд

2.2. Цэнэгийг өдөөх арга

2.3. Тэсэлгээний хэлхээний /дараалал, удаашралын хугацаа/ тооцоо

2.4. Цэнэгийн бүтэц, өдөөгчийн байрлал

2.5. Тэсрэх материалын зарцуулалтын тооцоо

2.6. Тэсэлгээний нөлөөллийн хүрээнд байрлах объектын /барилга, байгууламж, шугам хэлхээ/ аюулгүй байдлыг хангах аюултай бүсийн тооцоо, хамгаалах арга

2.7 Тэсэлгээний бүсийг агааржуулах болон энэхүү дүрэмд заасан аюулгүй ажиллагааны бусад арга хэмжээг зааж, тэсэлгээний ажил болон холбогдох бусад бүхий л шаардлагатай ажлуудыг аюулгүй зохион байгуулах

шийдлийг тусгасан байна.

3. Гүйцэтгэгч уурхайд тэсэлгээний ажлыг явуулах ба бутлагдлын дундаж хэмжээг 0.7 метрээс ихгүй болгож бутлан сийрэгжүүлэх үүргийг хүлээнэ.
4. Тэсэлгээний ажлыг уурхай дээр гүйцэтгэгч нь ажил үүргээ аюул осолгүй, технологийн горимын дагуу хэвийн явуулах машин тоног төхөөрөмж, ажлын багаж хэрэгслээр бүрэн хангагдсан байна.

	Уулын цул (м3)	Доголын өндөр (м)	Цооног болон эгнээ хоорондын зай	Устай цооногийн эзлэх хувь
1-р блок	108,000	10м	4х5	40
2-р блок	72,000	10м	3х4	40-45
Нийт	180,000			40

Боловсруулсан: Д.Эрдэнэбаяр Төлөвлөлтийн инженер: Д.Эрдэнэбаяр

Хянасан: _____ Ерөнхий инженер Г.Наранцогт

Тэсэлгээний ажлын паспорт